

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024.04.26

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлыг, хурал хийхээр товлосон зарын дагуу 2024.04.26 ны өдрийн 14 цагт Компанийн хурлын танхимаас цахим хэлбэрээр шууд дамжуулав.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2022.04.26 ны өдрийн "Хүчин төгөлдөрт тооцох тухай" №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга И.Галтхүү хүндэтгэн үзэх шалгаанаар оролцох боломжгүй тул нягтлан бодогч Б.Хонгорзул уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалынр хуудсанд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Б.Хонгорзул : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 3.800.721 ширхэг хувьцаа эзэмшсэн 9884 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 2.900.110 ширхэг хувьцаа эзэмшсэн 54 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байна. Энэ нь нийт хувьцааны 76,3 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурал дарга тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, аж үйлдвэрийн гавьяат ажилтан Л.Янжин хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хурал даргалах боломжгүй тул "ХКҮ"-ийн гүйцэтгэх захирал П.Энх-Амгалан хурлыг нээж хурлын дэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зарим гишүүдийг сонгох, 2024 оны төсвийг батлах
 4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
-
1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2024 оны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Г.Бүдрагчаа илтгэв.
 2. Компанийн 2023 оны санхүүгийн тайланг компанийн ерөнхий нягтлан бодогч Мөнхжаргал тайлагнав.
 3. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн намтар болон 2024 оны төсөв
 4. "Ногдол ашиг хуваарилах" тухай ТУЗ-ийн тогтоолыг хөтлөгч уншиж танилцуулав.

Асуулт 1: Хуучин барилгуудаа нурааж байгаа юм байна. Энэ талаар мэдээлэл ойлголт ерөөсөө байхгүй байна. Дараа нь ямар ажилд төлөвлөж байгаа вэ?

-Ерөнхий инженер Н.Маралсүрэн инженерийн ашиглалтгүй байгаа хуучин барилгуудаа нураагаад 80 хувьтай, газар чөлөөлтийн ажлаа дуусах шатанд явж байна. энэ болохоор МИК 80 төслийг барьж, энд төслийн хоёрдугаар шат болох хөргөлттэй агуулах, мах шулах, ангилах цех, лавлагаа лаборатори, жимс хүнсний ногоо хадгалах үйлдвэр барьж байгаа. Дар нийт 3,000 мкв талбай барилга, барьж байгуулахаар энэ ондоо болох төслийн 2р шатны эхний ээлжийн барилга болох мах ангилах шулах барилга, дарихаар үйл ажиллагаа маань газар чөлөөлөлтийн ажил маань дуусах үед нь явж байгаа юм.

Асуулт 2: Нөөцийн мах хэдэн цэгээр худалдаагаа явуулж байгаа вэ? Хэр их мах бэлтгэгдсэн бэ?

-Борлуулалтын албаны дарга Н.Алтан-эрдэнэ: Энэ ажилтны компани энэ онд нийслэл хотын хүн амын хэрэгцээнд зориулан 4 цэгээр махыг бэлтгэсэн. Захирагчийн ажлын албанаас хуваарилсан Баянгол, Дагуул, Сонгинохайрхан дүүргийн нийт 69 дэлгүүрээр нөөцийн махыг худалдаа явуулж байгаа.

Асуулт 3: Ногдол ашиг өгөх үү? Яаж өгөх вэ?

-Ерөнхий нягтлан бодогч С.Мөнхжаргал: 2021 онд дуусалх ногдол ашигийг бид өөрийн компани дээрээ бүртгээд өгч байгаа. Энэ онд мөнгөөр тухайн хүний данс руу шилжүүлж өгч байгаа. 2022 онд эхлээд УЦТХ-тэй хамтран гэрээ байгуулан ажиллаж байгаа. 2022 онд эхлээд УЦТХ-ийг УЦТХ-р нэгдсэн журмаар тараалт хийгдэнэ.

Асуулт 4: Борлуулалтын орлого өсч байгаа нь ямар шалтгаантай вэ?

-Ерөнхий нягтлан бодогч С.Мөнхжаргал: 2021 онд 13 оныг харьцуулахад манай борлуулалтын орлого 90.8% өсч байсан. Энэ онд 13 оны борлуулалтын орлого 68.7 тэрбум төгрөгний борлуулалтын орлого байгаа. Энд гол нөлөөлсөн хүчин зүйл бол 2023 онд БНХАУ болон Бразил руу экспортын махыг буюу нийлээд 3,000тн махыг экспортод гаргасан. Бразил тайлан дээр мөн дурдсаны дагуу дотооддоо болон экспортод гэсэн 2 том чиглэлийг барьж худалдаагаа хийдэг. Дотооддоо үйлдвэрлэл болох хэрэгсэл гэсэн 2 том чиглэлд борлуулалтаа хийдэг. 2023 онд борлуулалт өсөх шалтгаан гол хүчин зүйл бол экспортын борлуулалт бас тодорхой хэмжээгээр өсөх шалтгаан Борлуулалт тодорхой хэмжээгээр өссөн байгаа.

Асуулт 5: Энэ онд 1,000 тонн мах экспортолж, дотоодод төлөөлөсөн байсан. Шулах цехээ нурааж байгаа юм байна. Яаж бэлтгэж байгаа вэ?

-Үйлдвэрийн дарга Н.Одгэрэл: Энэ хуучин барилга бодогч байгаа бөгийн мах хөлдөөдөг 16 тунел байдаг түүнийхээ 4 тунелийг барьж, энд 1,800 мкв талбайг шинэ цех болгон тохижуулж байгаа. Энэ ажлыг 2023 онд 01 сард бүрэн ашиглалтанд орно. Энэ цехдээ бид 70-80 кг-ыг экспортлох зорилготойгоор ажлаа эхэлчихсэн явж байна.

Хурлын дарга : Өөр санал хүсэлт байхгүй тул санал хүсэлтийг үүгээр тасалъя. Та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Б. Хонгорзул "Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах" тухай тогтоолыг уншиж танилцуулав.

Компанийн нийт 3.800.721 ширхэг хувьцаа эзэмшиж буй 9.884 хувьцаа эзэмшигчдээс хуралд 2.900.110 ширхэг хувьцаа эзэмшсэн 54 эзэмшигч оролцов. Тооллогын комисст ирсэн саналын хуудас 54 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын хуудас 50 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын хуудас тоо 4 байна.

1. Компаний 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь татгалзсан түдгэлзсэн санал байхгүй.
3. Компанийн ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг 12.750.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо байхгүй.
4. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр :
 - Б.Намууныг сонгохыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
 - Б.Саруулыг сонгохыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр :

- Т.Золбаярыг сонгохыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй
 - Б.Оргилыг сонгохыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй
5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 100 төгрөгөөр хувиарлахыг зөвшөөрсөн 2.899.975 ширхэг хувьцаа буюу нийт саналын 76 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй байна. Иймд дээрхи ирсэн саналуудыг үндэслэн

ТОГТООХ НЬ: Хурлаар хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай гэж танилцууллаа.

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас №01 тоот тогтоол гаргав.

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй
2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - Б. Намуун

- Б.Саруул нарыг

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр :

- Т.Золбаяр
- Б.Оргил нарыг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай

4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг 12.750.000 төгрөгөөр баталсугай.
5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 100 төгрөгөөр тогтоосугай гэж тогтоолыг уншиж танилцуулсанаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ажиллагаа өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

Л.ЯНЖИН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



И.ӨЛЗИЙБАЯР